

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН САЛБАРЫГ БҮСЧЛЭН ХӨГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА, ХЭРЭГЦЭЭ, БОЛОМЖ

(Монгол улсын Зүүн бүсийн жишээгээр)

*Demand, Market & Possibility of regional development of professional education
(in Eastern Region example of Mongolia)*

Необходимость, потребность и возможность регионального развития профессионального образования
(на примере Восточного региона Монголии)

Э.Ундармаа*, ЖЦэвээнжав**

*ДИС, **ДИС, ШУТИС

*undarmaa@dornod.edu.mn, **btseveen2003@yahoo.com

Хураангуй

Аливаа улс орны, түүний дотор Монгол улсын хөгжил дэвшил, хүн зоны амьдрал ахуйд боловсрол, мэргэжил, ажил эрхлэлт шийдвэрлэх ач холбогдолтой бөгөөд гол хөдөлгөөч хүч нь болно.

Хөгжлийн энэ чухал асуудлаар олон тооны хууль эрх зүйн, бодлогын баримт бичгүүд, хөтөлбөр, шийдвэрүүд байгааг бид Боловсролын Бүс нутгийн хөгжлийн хууль эрх зүйн баримт бичгүүд, тогтоол шийдвэрүүд, төсөл хөтөлбөрүүд, судалгааны ажлууд гэж 2 хэсэгт хуваан тоймлон авч үзсэн бөгөөд эндээс Мэргэжлийн боловсролын салбарыг бүсчлэн хөгжүүлэх хэрэгцээтэй бөгөөд боломжтой энэ асуудал нийгэм эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой, судлан шийдвэрлэх шаардлагатай, тулгамдсан чухал асуудал гэж үзсэн болно.

1. Боловсролын салбарын үзэл баримтлал, хууль эрх зүй

Монгол улсын Боловсролын тухай (2002) хуульд "...Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино", Дээд боловсролын тухай (2002) хуульд "...Дээд боловсролын сургалтын байгууллага нь их сургууль, дээд сургууль, коллеж байна. Их сургууль нь эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын, дээд сургууль нь сургалт-эрдэм шинжилгээний, коллеж нь сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй байна", Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай (2009) хуульд "...Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв зэрэг хэв шинжтэй байж болно, Политехник коллеж нь техникийн боловсролын сургалт эрхэлдэг байгууллага байна. Сургуулиас гадуурх сургалтын ажил эрхэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, иргэн өөрийн үйл ажиллагааны чиглэлээр нийгэм, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, хууль зүй, байгаль орчин, гоо зүй, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, гэр бүлийн болон ахуйн хүрээний асуудлаар тусгай хөтөлбөрийн дагуу хүүхэд, насанд

хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, боловсрол, мэргэшлээ дээшлүүлэхэд нь тусалцаа үзүүлж болно. Иргэнд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд зайлшгүй шаардагдах мэргэжил эзэмшүүлэх, мэргэшил дээшлүүлэх сургалтыг бүх шатны сургууль, бусад аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхэлж болно" гэж тус тус хуульчилсан.

Дээд боловсролын зорилго нь төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тулгуурлан боловсролын үндсэн зарчим, олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн иргэнд дээд боловсрол олгоход оршино. Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх, бие хүн өөрийгөө нээж хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ. Дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэших хэсгээс бүрдэх бөгөөд эдгээр хэсэг тус бүрийн агуулга нь дараах зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Үүнд:

1. Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх
2. Мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид шинжлэх ухаан, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр мэргэжил эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол- арга зүйн мэдлэг эзэмшүүлэх
3. Мэргэших хэсгийн агуулга нь суралцагчид нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тухайн мэргэжлээр мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлэх

Уг хуульд:

1. **Их сургууль** нь шинжлэх ухааны хэд хэдэн чиглэлээр суурь ба хавсарга судалгаа явуулдаг, бакалавр, магистр, докторын сургалт эрхэлдэг, үйлдвэр, үйлчилгээний бааз, лаборатори бүхий эрдэм шинжилгээ-

сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын байгууллага байна.

2. **Дээд сургууль** нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж дипломын болон бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллага мөн.

3. **Коллеж** нь дипломын болон бакалаврын сургалт эрхэлдэг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн байгууллага байна.

2009 онд шинэчлэн найруулж баталсан Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуульд энэ хуулийн зорилт нь мэргэжлийн боловсрол, сургалтын агуулга, зорилго, бүтэц, түүний удирдлага, зохион байгуулалтыг тодорхойлж, иргэнд мэргэжлийн боловсрол эзэмшүүлэх, мэргэжлийн урчадвар олгох, дээшлүүлэх сургалтыг хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, ажил олгогчийн захиалгад нийцүүлэн зохион байгуулах, энэ үйл ажиллагаанд оролцогчийн эрх, үүрэгтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэж заасан.

Уг хуульд **“мэргэжил”** гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, дадлын цогцыг, **“мэргэжлийн боловсрол”** гэж тодорхой мэргэжлийн үйл ажиллагааг гүйцэтгэх хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг, **“техникин боловсрол”** гэж техник, технологийн үйл ажиллагааг гүйцэтгэх, удирдах хэрэгцээнд нийцүүлж зохион байгуулалттай сургалтаар эзэмшүүлсэн үйлдвэрлэл, техник, технологийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн болон харилцааны соёлын төлөвшлийг, **“мэргэжлийн сургалт”** гэж тодорхой ажил, хөдөлмөр эрхлэхэд шаардагдах мэргэжлийн ур чадвар олгох, дээшлүүлэх, давтан сургах, дадлагажуулах, хөдөлмөрийн болон харилцааны соёл төлөвшүүлэх, аж ахуй эрхлэх мэдлэг олгох үйл ажиллагааг, **“мэргэшил”** гэж тодорхой мэргэжлийн хүрээнд ажил гүйцэтгэхэд шаардагдах мэргэжлийн мэдлэг, чадвар, дадлын түвшинг, **“мэргэжлийн суурь чадвар”** гэж нийгмийн харилцаанд оролцоход шаардагдах мэдлэг, чадвар, төлөвшлийг, **“мэргэжлийн үндсэн чадвар”** гэж аливаа ажил үүрэг бие даан гүйцэтгэх, ажиллах, өөрчлөлтөд зохицон өсөж хөгжих чадварыг хэлнэ, ойлгоно гэж тус тус хуульчлан заасан байна.

II. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, бодлого шийдвэр, хууль эрх зүй

2.1. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, шаардлага, хэрэгцээ

Нутаг дэвсгэр том, дэд бүтцийн хөгжил харьцангуй сул, төвөөс алс байрлалтай бүс нутгуудыг бүсчилсэн зарчмаар хөгжүүлэх нь

нийгэм, эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой болно.

Манай улс нутаг дэвсгэрийнхээ хэмжээгээр дэлхийд 19-д ордог бөгөөд газар зүйн хувьд дорноос өрнө рүү сунасан онцлог байршилтай болно. Монгол улсын Төр засгаас Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалыг боловсруулан баталж, хэрэгжүүлж байна.

2.2. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжилт


Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 14 ний өдрийн 57 дугаар тогтоолоор анх “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсан.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын эрхэм зорилго нь тус улсын газар, түүний баялаг, газар тариалан, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн нөөц, оюуны чадавхийг байгаль орчны даацад зохицуулан оновчтой ашиглах үндсэн дээр хүн ам, үйлдвэрлэлийн өнөөгийн зохисгүй бөөгнөрлийг задалж, хот, хөдөөгийн хөгжлийн ялгаа, аймаг, бүс нутаг хоорондын тэгш бус, тэнцвэргүй байдлыг багасгаж хөгжлийн түвшинг ойртуулах, үндэсний эдийн засаг, нийгмийн дэвшлийг түргэтгэх дотоод, гадаад таатай орчныг бүрдүүлэхэд оршино.

“Бүс нутаг” гэж аймаг, сум, нийслэл, дүүрэг, хот, тосгоны хоорондын нийгэм, эдийн засгийн харилцаа холбоо, тусгай хамгаалалттай газар нутаг тэдгээрийн орчны бүс, хүн амын нутагшилт, хөдөө аж ахуй, аялал жуулчлал болон аж ахуйн бусад салбар, салбар хоорондын уялдаа холбооны орон зайн хөгжил, байршлын хүрээг хамарсан Монгол улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсэг буюу эдийн засаг, нийгмийн цогцолборыг хэлнэ.

Зүүн бүсэд: Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгууд хамрах бөгөөд уул уурхайн олборлох, боловсруулах үйлдвэр, эрчимжсэн газар тариалан, мал аж ахуй, жижиг, дунд үйлдвэр, аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Дорнод аймагт Бүсийн оношлогоо, эмчилгээний төв байгуулагдан ажиллаж байна. Энэ бүсэд шинээр Байгалийн голомтот халдварт өвчний бүсийн төв байгуулан ажиллуулах нь чухал ач холбогдолтой. Учир нь Оросын Холбооны Улсын Чита мужтай төмөр замаар холбогдож, автозамын байнгын ажиллагаатай Ульхан, Эрээнцавын хилийн байнгын ажилагаатай 2 боомт ажилладаг. Хятад Улсын Манжуур, Хайлаар, Харбинаас Дорнодын Хавирга хилийн боомтоор зорчигчид нэвтрэн хилийн худалдаа, малын гаралтай түүхий эд, хүнсний ногоо, бараа солилцоо хийдэг. Эдгээр байдал нь олон улсын хөл хориот өвчин холер зэрэг гарч болох боломжтой учир гоц аюулт халдварт өвчний чиглэлээр бүсийн төрөлжсөн төв ажиллах нь чухал юм.

Манайд мөн түүнчлэн УИХ-ын 2016 оны 19-р тогтоолоор “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” батлагдан хэрэгжиж байгаа бөгөөд энэ баримт бичигт улс орны нийгэм-эдийн засгийг бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлал, бодлого батлагдсан болно.



Монгол улсын 1,56 сая км² нутагт 3 057 800 хүн ам амьдарч 2017 оны байдлаар Зүүн бүс нутагт улсын төсвийн хөрөнгө оруулалтын 4,9% хийгдэж, энэ бүс нутагт манай улсын нийт мал сүргийн 15,1%, Газрын тосны олборлолтын 95-98% явагдаж байна. Эндээс Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, шаардлага, хэрэгцээ, түүний дотор боловсролын нэн ялангуяа Мэргэжлийн боловсролын хүний нөөцийг зардал багатайгаар бүс нутагт бэлтгэх, нутаг оронд нь дадлагажуулан ажиллуулах хэрэгцээ, шаардлага урган гарч байгаа болно.

III. Мэргэжлийн боловсролын салбарыг бүсчлэн хөгжүүлэх шаардлага, хэрэгцээ, боломж

3.1. Бүсчилсэн хөгжил ба боловсрол, мэргэжлийн боловсролын салбар

Аливаа хөгжлийн гол түлхүүр бол хүний, тэр тусмаа мэргэжлийн хүний нөөц, тэдгээрийн идэвхтэй үйл ажиллагаа байдаг. Боловсролтой, мэргэжилтэй хүний нөөцийг бүс нутаг, төрж өссөн орон нутаг, ирээдүйд ажиллах газар нь бэлтгэх нь хамгийн зөв зүйтэй, эдийн засаг менежментийн ихээхэн ач холбогдолтой юм. Бүс нутагт шаардлагатай мэргэжилтний хэрэгцээг хүн амын тоо (N), бүс нутгийн хүн амд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)-ний Q хэмжээтэй хэрхэн хамааралтай болохыг бид эдийн засаг-математикийн аргаар судалсан бөгөөд энд шаардлагатай мэргэжилтний тоо $n = f(N)$, $n = Y(Q)$ хамааралтай, харин мэргэжлийн төрөл, бүс

нутгийн хүн, бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн онцлогоос хамааралтай болохыг тогтоов. Зүүн бүс нутагт бусад бүс нутгийн нэгэн адил Боловсрол, Хүмүүнлэг, Эдийн засаг, Менежментийн нийтлэг мэргэжлүүдээс гадна 3 улсын хил залгаа нутаг, олон боомт гарцтай, Тамсаг Мэнэнгийн уудам тал нутаг, Халх гол-Нөмрөгийн дархан цаазат газар, алдарт Халхын гол, Хамар даваа, Баянцагааны нуруу, дорнын цэнхэр сувд Буйр нуур, эзэн Чингисийн төрсөн нутаг Дэлүүн болдог, Дарьгангын домог түүхт Алтан овоо, Шилийн Богд, Ганга нуур зэрэг түүх дурсгалын болон байгалийн үзэсгэлэнт газруудтай тул Аялал жуулчлалын, эх орны газрын тосны нөөцийн 95-98% байдгийн хувьд Газрын тосны мэргэжлийн шат шатны мэргэжилтнүүд, Дорнод, Гурванбулаг, Мардайн ураны, Цав, Төмөртэй овоо, Мөнгөн-Өндөрийн мөнгө, цайр, хар тугалга зэрэг холимог металлын, Бүрэнцогт, Түмэнцогт, Салаагийн гянтын, Арын нуурын төмрийн, Цагаанчулуут, Өвөлжөөтийн зэрэг алтны орд, уурхайтай тул Уул уурхайн, мэдээж Дорнод монголын үржил шимт уудам нутагтай тул Хөдөө аж ахуйн, юуны өмнө, Газар тариалангийн мэргэжилтнүүд шаардлагатай байгаа болно.

Бүс нутагт мэргэжилтэн бэлтгэх хэрэгцээ, шаардлага, менежментийн асуудлыг бид Газрын тосны мэргэжилтнүүдийн жишээн дээр авч үзэж, энэ чиглэлийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, дадлагажуулах, сургалтын материаллаг баазыг бэхжүүлэх, судалгааны ажил явуулахад тулгарч буй хүндрэлүүдийг хамтран шийдвэрлэх, улмаар төр захиргааны болон газрын тосны мэргэжлийн

байгууллагуудаас бодлогын, мэргэжлийн дэмжлэг авах боломжуудын талаар хамтран ярилцах зорилгоор “Зүүн бүсийн газрын тосны сургалт-судалгаа, ажил эрхлэлтийн асуудлууд” сэдэвт онол-практикийн семинарыг Дорнод их сургууль, Дорнод Политехникийн коллеж, Монголын Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг, Газрын тосны сургалт, судалгаа, мэдээллийн төв хамтран 2018 онд Чойбалсан хотод зохион байгуулсан нь энэ судалгааны ажлын нэгэн чухал хэлэлцүүлэг болсон.

Семинарт Дорнод их сургууль, Дорнод Политехник коллежоос хамтран зүүн бүсийн инженер-техникийн мэргэжилтний, түүний дотор, Газрын тосны мэргэжлийн сургалт-судалгаа-ажил эрхлэлтийн талаар илтгэл бэлтгэн хэлэлцүүлж байсан.

Семинарт оролцогчид Дорнод их сургуульд Монгол улсын БШУСЯ-ны “Дээд боловсролыг дэмжих төсөл”-ийн хүрээнд АХБ-ны санхүүжилтээр 2018 онд шинээр байгуулагдсан “Газрын тосны сургалт-судалгааны лаборатори”, Дорнод Политехник коллежийн Газрын тосны олборлолтын операторийн сургалтын төхөөрөмжүүдтэй танилцсан.

Мөн УУХҮЯ, АМГТГ, Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгуудын ЗДТГ, БОАЖГ, МХГ, эдгээр аймгуудын газрын тосны хайгуулын талбай бүхий сумдын удирдлага, байгаль орчны мэргэжилтнүүд, газрын тосны хайгуул-олборлолтын, туслан гүйцэтгэгч (харамсалтай нь зүүн бүсд газрын тосны олборлолтын үйл ажиллагааг эрчимтэй явуулж байгаа хамгийн том ажил олгогч Петрожайна-Дачин-Тамсаг компаний 19, 21-р талбайн үйлдвэрлэлийн баазаас болон Улаанбаатар хот дахь төв оффисоос хэн ч оролцоогүй болно) болон хөдөлмөр зуучлалын компаниуд, газрын тосны бүтээгдэхүүний импорт-хангамжийн компаниуд, газрын тосны мэргэжилтэн бэлтгэдэг сургалтын байгууллагууд, мэргэжлийн төрийн бус байгууллагуудын төлөөллүүд оролцож, газрын тосны сургалт-судалгаа-ажил эрхлэлтийн талаар мэдээлэл болон санал бодлоо солилцон ярилцаж, уриалга гаргасан.

Энэхүү судалгааны ажлын зохиогчид бид “Зүүн бүсийн газрын тосны сургалт, судалгаа, ажил эрхлэлтийн асуудлууд” сэдэвт онол-практикийн семинарыг биечлэн зохион байгуулж, судалгааны илтгэл тавьж хэлэлцүүлж байсан болно.

Дорноос өрнө тийш сунасан уудам нутагтай Монгол эх орноо бүсчлэн хөгжүүлэх нь манай төр засгийн бодлого, бүс нутгийн хүн зоны хүсэл байдаг бөгөөд үүнд хүний нөөцийг, түүний дотор, инженер-техникийн мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх, дадлагажуулах, нутаг оронд нь ажиллуулах асуудал ч орж байдаг билээ.

Зүүн бүс нутаг бол юуны өмнө эх орны газрын тосны өлгий нутаг бөгөөд энэ нутагт газрын тосны хайгуул-судалгааны ажил 1950-иад онд явагдаж байгаад удаан хугацаагаар завсарлаад 1990-ээд оноос дахин эрчимжин сэргэж, 19-р талбайд

СОТАМО-3-р цооногоос газрын тос оргилон Монгол төрийн анхны Ерөнхийлөгч маань дээлээ мялааснаас хойш эдүгээг хүртэл багагүй хугацаа өнгөрч, одоо жилдээ нэг сая гаруй тонн тос олборлон, борлуулж байна, удахгүй эх орондоо боловсруулж, бүтээгдэхүүн үйлвэрлэхийг Монгол түмэн хүсэн хүлээж байна.

Хөгжлийн энэ төлөв хандлагын дагуу Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгуудыг хамрах эх орны Зүүн бүс нутагт газрын тосны мэргэжилтэй ажилчид, операторуудыг бэлтгэх ажил Дорнодын техник технологийн, эдүгээ Политехник коллежид 2008 оноос эхэлж, нийт 258 газрын тосны мэргэжилтэй ажилчин, операторуудыг бэлтгэсэн ба одоо 30 хүн суралцаж байна.

Энэ бүс нутагт инженер-техникийн дээд мэргэжилтэй хүмүүсийг бэлтгэх ажил Дорнод их сургуульд 2015 оноос Газрын тосны инженерийн мэргэжлээр эхэлж, одоо 3-р дамжаанд-19, 2-р дамжаанд-12, 1-р дамжаанд-4 оюутан, нийт 35 оюутан суралцаж байна. Дорнод их сургууль НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага ЮНЕСКО-ийн гаргасан олон улсын дээд боловсролын хөтөлбөрийн шинэчлэлийн дагуу манай БШУСЯ-наас баталсан Газрын тосны инженерийн багцалсан хөтөлбөрийн дагуу сургалтыг явуулж байгаа бөгөөд “Дээд боловсролын хөтөлбөрийн шинэчлэл” төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр нийт 134 сая төгрөгийн өртөг бүхий Газрын тосны сургалт-судалгааны лабораторийг байгуулан ашиглалтад оруулж, сургалт-судалгаанд ашиглаж эхлээд байна.

Улс орноо бүсчлэн хөгжүүлэх үзэл баримтлалын дагуу бүс нутагт мэргэжлийн хүний нөөц, түүний дотор, инженер-техникийн ажилтнуудыг бэлтгэхэд суралцагсадыг дадлага хийлгэх, мэргэжлийн чиглэлээр судалгааны ажил явуулах, нэн ялангуяа, бэлтгэгдсэн ҮНДЭСНИЙ мэргэжилтнүүдийг дадлагажуулах, ажлын байраар хангах асуудал хурцаар тавигдаж байна.

Энэ л цаг үе, орон зайд, тодорхой асуудлаар, тухайлбал, эх орны газрын тосны бүс нутаг-Зүүн бүсд энэ чиглэлээр шат шатны мэргэжилтнүүд бэлтгэгдэж байгааг, тэднийг сургаж дадлагажуулах, улмаар, ажлын байраар хангахад Төр засаг, Мэргэжлийн салбар, Орон нутгийн засаг захиргаа, нэн ялангуяа, энэ бүс нутагт үйл ажиллагаа явуулж байгаа-ажил олгогчид болох газрын тосны хайгуул-олборлолт-тээвэрлэлтийн болон газрын тосны бүтээгдэхүүний импорт-хангамж-нийлүүлэлтийн байгууллагууд чухал үүрэгтэйг энэ уулзалтаар ярилцаж байсан болно.

3.2. Бүс нутгийн нийгэм-эдийн засгийн болон мэргэжлийн боловсролын онцлог

Зүүн бүс нутагт нэгдмэл тогтолцоотой улсын хувьд төр засгийнхаа нэгэн адилаар хуулиа дээдэлсэн, хүмүүнлэг ардчилсан засаглал бүхий нийгмийн тогтолцоотой, зах зээлийн эдийн засагтай, Газрын тос, Уул уурхай, Аялал жуулчлал,

Хөдөө аж ахуйн салбарууд эдийн засгийн суурь болж байна. Нийгэм-эдийн засгийн тогтолцооны энэхүү онцлогийн дагуу Мэргэжлийн боловсролын тухайн салбаруудыг түлхүү хөгжүүлэх бодлого баримтлах, онол-арга зүйг боловсруулах, бүс нутагт нь багшлах хүний нөөцийг бэлтгэх, сургалт-судалгааны материаллаг баазыг бий болгох, бэхжүүлэх явдал чухал байна. Энэ талаар төр засаг, боловсролын салбараас мэргэжлийн боловсролыг бүс нутагт нь олгох талаар бодлого боловсруулж, дэмжлэг тусалцаа үзүүлж байгааг талархан тэмдэглэх нь зүйтэй юм.

Дорнод нутагт Дорнодын багшийн сургууль 1991 оноос Дорнод дээд сургууль, 2015 оноос Дорнод их сургууль болж, 2019 онд 3 дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн болно. Тус сургууль Боловсрол, Гадаад хэл, Аялал жуулчлал, Санхүү-нягтлан бодох бүртгэл, Эдийн засаг менежментийн мэргэжлээр дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж байсан бол их сургууль болсон 2015 оноос бүс нутагт туйлын чухал шаардлагатай инженер-технологийн мэргэжлээр, юуны өмнө, бүс нутгийн гол салбар Газрын тосны чиглэлээр инженер-технологийн мэргэжилтнүүдийг бэлтгэж эхэлсэн ба 2019 онд анхны төгсөлт хийж, бэлтгэгдсэн шавь нар 100 хувь ажлын байраар хангагдсан болно. Энэ чиглэлээр мэргэжлийн туршлагатай эрдэмтэн багш нарыг гаднаас урьж ажиллуулах, өөрийн залуу багш нарыг мэргэшүүлэх, дадлагажуулах чиглэлийг баримтлан ажиллаж, судалгааны ажил явуулж эрдэмтэн багш нартай болох зорилго тавин ажиллаж байна. Газрын тосны хайгуул-олборлолтын салбарт түлхүү хөрөнгө оруулалт хийж байгаа БНХАУ-ын хөрөнгө оруулалттай “Петрочайна-Дачин-Тамсаг” ХК-тай санамж бичиг, оюутны дадлагын гэрээ байгуулан оюутны дадлага практикийг явуулж байна. Бүс нутагт ихээхэн хөрөнгө оруулалт хийж хамтран ажиллаж байгаа БНХАУ-ын хэл соёлд оюутнуудыг түлхүү суралцуулж, мэргэжлийн чиглэлээр Зүүн Хойд Хятадын Газрын тосны их сургууль (*North East Petroleum University-NEPU of China*)-тай харилцаа, хамтын ажиллагааны гэрээтэй ажиллах болов.

Мөн Уул уурхайн чиглэлээр Ашигт малтмалын баяжуулалтын технологи хөтөлбөрөөр мэргэжилтэн бэлтгэх эрх авч, эхний элсэлтийг хийж, энэ чиглэлийн мэргэжилтэн бэлтгэх бэлтгэлийг хангах талаар ажиллаж байна. Энэ чиглэлээр хөрш зэргэлдээ ОХУ-ын Өвөр Байгалийн Хязгаарын Улсын их сургуультай харилцаа, хамтын ажиллагааны гэрээ байгуулан ажиллаж, Уул уурхайн мэргэжлээр 2+2, 2+3, 3+2 хөтөлбөрүүдээр хамтарсан сургалт явуулахаар төлөвлөж байна.

Мөн түүнчлэн БСШУСЯ-ны 2014 оны А/74 тушаалын дагуу Мэргэжлийн хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг багцлалтын дагуу явуулахын зэрэгцээ тухайн чиглэлээр МСҮТ-КОЛЛЕЖ – ИХ СУРГУУЛЬ-ийн шаталсан сургалтаар мэргэжилтэн бэлтгэх бодлогыг хэрэгжүүлж байна. Мөн Дорнод их сургууль өөрийн бүрэлдэхүүнд ахлах

сургуультай бөгөөд бүс нутагтаа мэргэжлийн хүний нөөц бэлтгэх чухал бааз суурь болж байна.

Мэргэжлийн хүний нөөцийг бүс нутагт нь бэлтгэх явдал нь дараах ач холбогдолтой болно. Үүнд:

Бүс нутгийн нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагын дагуу мэргэжлийн хүний нөөцийг бэлтгэх

Хүмүүсийг орон нутагтаа сурч, төгсөөд төрөлх нутагтаа ажиллаж, амьдрах, суурьших бололцоог олгох

Суралцагсад яг ижил хөтөлбөрөөр суралцаж, адилхан мэдлэг мэргэжил, дадлага чадварыг зардал багатайгаар орон нутагтаа, гэр орондоо байж эзэмших бололцоог олгох

Нийслэл Улаанбаатар болон төвийн сургуулиудын ачааллыг багасгах, хүн амын бөөгнөрлийг бууруулах, төвлөрлийг сааруулах давуу талтай.

3.3. Мэргэжлийн боловсролыг бүсчлэн олгох, хөгжүүлэх шаардлага, боломж

Монгол улсын нутаг дэвсгэр нь газар зүйн байршлын хувьд дорноос (зүүнээс) өрнө (баруун) тийш сунасан тогтоцтой, өргөн уудам бөгөөд юуны өмнө хөгжлийг Зүүн, Баруун, Төвийн гэсэн бүс нутгаар төлөвлөн хөгжүүлэх нь тулгамдсан чухал зорилт болоод байна. Иймээс ч манай төр засаг, боловсролын салбараас Зүүн бүсд Дорнод их сургууль, Баруун бүсд Ховд их сургуулийг тус тус байгуулан ажиллуулж байгаа болно. Энэ 2 сургууль бол төрийн өмчит 12 сургуулийн 2 нь бөгөөд цаашид төр засаг, боловсролын салбар, орон нутгийн төрийн захиргааны болон аж ахуй, бизнесийн байгууллагуудаас улам ихээр дэмжин ажиллах шаардлагатай байгаа болно.

Хүний эрх, эрх чөлөө, эрх ашгийг дээдэлдэг манай нийгэмд мэргэжлийн боловсролыг бүсчлэн олгох, хөгжүүлэх нь нэн тэргүүнд боловсрол мэргэжилтэй болох, улмаар ажил үйлдвэрлэл эрхлэх зорилготой хувь хүмүүс, иргэдэд ихээхэн ач холбогдолтойг Дорнод их сургуулийн жишээгээр тооцоолон харуулья.

Тооцооллын өгөгдлүүд:

Суралцах хөтөлбөр ижил

Суралцах хугацаа адил

Сургалтын төлбөр тэнцүү

Давуу талууд:

Орон нутагтаа суралцах тул орон нутаг-нийслэлийн хооронд явах замын зардал хэмнэгдэнэ.

Өөрийн гэртээ болон хямд зардлаар түрээсийн байранд амьдрах тул байр сууцны зардал 30-50% хэмнэлттэй.

Дадлагаа орон нутагтаа хийнэ, ажлын байранд дадлагажих бололцоотой.

Төгсөөд ажлын байр үндсэндээ бэлэн, ажиллах, амьдрах нөхцөл бэлтгэгдсэн байна,

Тооцоолол:

Сургуульд очиж, ирэх зардлын хэмнэлт-4 жил*2 удаа*2тал*40 000 төг (Чойбалсан-Улаанбаатар,

Улаанбаатар-Чойбалсан чиглэлээр, автобусны тийз, амь даатгал-33,600төг+замын хоол, ундаа-6,400төг)=640 000төгрөг, дадлагад явах зардлын хэмнэлт 2 удаа*2тал*40 000 төг=160 000төг, нийт хэмнэлт-800 000 төг

Байрны зардлын хэмнэлт-400 000төг/жил*4жил*(0.3-0.5)=480 000-800 000 төгрөг

Нийт хэмнэлт 800 000 + (480 000-800 000)=1 280 000-1 600 000төгрөг

Хэмнэлтийг зөвхөн мөнгөн хэлбэрээр тооцохоос гадна бас цаг хугацаа, ачааллын хэмнэлтийг тооцвол зохино.

Их, дээд сургуулийн оюутны нэг жилийн сургалтын төлбөрийг дунджаар-2 000 000-2 500 000 гэж тооцвол Дорнод аймгийн жишээгээр тооцоход орон нутагтаа биш төвд очиж суралцахад суралцагчаас гарах жилийн зардал 10-20 %-иар нэмэгдэж байна.

Дүгнэлт, санал:

1. Мэргэжлийн боловсролыг бүс нутагт нь олгох, нэн ялангуяа Зүүн, Баруун зэрэг алслагдсан бүс нутгуудад Их, дээд сургуулиудыг бодлогоор дэмжин ажиллах шаардлагатай нь харагдаж байна.
2. Мэргэжлийн хүний нөөцийг (ЕБС+МСҮТ) >Коллеж > гэсэн шаталсан зарчмаар бэлтгэх нь хамгийн оновчтойг Газрын тосны мэргэжлийн жишээн дээр судлан тогтоосон болно.
3. Бүхэлдээ өргөн уудам нутаг дэвсгэртэй Монгол улсын хувьд бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, онол арга зүйн дагуу мэргэжлийн хүний нөөцийг бүс нутгийн хөгжлийн онцлог, хэрэгцээ шаардлагад тохируулан бүс нутагт нь бэлтгэх, дадлагажуулах, ажиллуулах нь ихээхэн оновчтой болохыг энэхүү судалгаагаар харуулав.

Ашигласан материал

1. Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал Улсын Их Хурлын 2001 оны 6 дугаар сарын 14 ний өдрийн 57 дугаар тогтоол “Төрийн мэдээлэл сэтгүүл”, УБ, 2001, №28, 740х
- “Монгол улсын үндэсний хөгжлийн хөтөлбөр боловсруулах арга зүй, аргачлал” УБ
2. “Монгол улсын хөдөөгийн хөгжлийн стратеги” УБ. 2002. НҮБ-ын хүнс хөдөө аж ахуйн байгууллага, Дэлхийн банк, НҮБ-Хөгжлийн хөтөлбөр, Английн олон улсын хөгжлийн газар. х 26-27
3. ҮСХ. Бүс нутгийн нийгэм-эдийн засгийн үзүүлэлтүүдийн харьцуулсан судалгаа УБ, 2018, 43х
4. Дэлхийн банк, Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд, 2016 он
5. Б.Баярсайхан Монгол улсын бүсчилсэн хөгжлийн бодлого УБ, 2019, 22х
6. Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 УИХ-ын 2016 оны 19-р тогтоол
7. Э.Ундармаа. Дорнод нутагтаа дэлхийн боловсролыг эзэмших боломж Дорнод сонины 2019-11-20 №32
8. Э.Ундармаа, Ж.Цэвээнжав. Инженер-технологийн хүний нөөцийг бүс нутагт бэлтгэх, дадлагажуулах, ажиллуулах асуудал. Дорнод, Чойбалсан, 2019-4-26
9. Э.Ундармаа, Ж.Цэвээнжав. Зүүн бүсийн газрын тосны сургалт-судалгаа-ажил эрхлэлтийн асуудлууд Дорнод, Чойбалсан, 2019-4-26
10. Ж.Цэвээнжав. Инженерийн мэргэжилтэн бэлтгэх арга зүйн асуудлын эргэн тойронд дахин нэг өгүүлэхэд (Газрын тосны инженерийн мэргэжлийн жишээн дээр). УБ, Газрын тос (Oil & Gas)-2017, 23, 319-320х
11. Ц.Энхбаяр, Б.Соёлмаа, Ц.Энхтуяа. Зүүн бүс нутагт инженерүүдийг бэлтгэж эхэллээ. УБ, Газрын тос (Oil & Gas)-2016, №22, 327-329х